



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ТАЙЛАН

ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1-т “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт Төрийн аудитын тухай хуульд заасан аудит хийж Улсын Их Хуралд танилцуулах” гэж заасан чиг үүрэг, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 09 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТ 60.1 ХУВЬТАЙ, ЗОРИЛТОТ ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА

Аудитын тайланг хүргүүлсэн:

УИХ-ын Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн Байнгын хороо, Төрийн байгуулалтын Байнгын хороо, УИХ-ын Тамгын газрын хяналт шалгалт үнэлгээний газар, ЗГХЭГ, ЭЗХЯ, Сангийн яам, Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлсэн.

Улаанбаатар хот
2023 оны 03 дугаар сар

Аудитын харилцан хамаарал	Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т1 "хөгжлийн бодлого" гэж улс, салбар, салбар хооронд болон ..., урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг хэлнэ" гэж заасан.
Аудитын зорилго, зорилтууд	Монгол Улсад "Алсын хараа-2050"² урт хугацааны хөгжлийн бодлого, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл"³ дунд хугацааны хөгжлийн бодлого, "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө" богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг үндэслэн улс орны хөгжлийг тодорхойлж, чиглүүлж байна. Монгол Улсын Хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүн бодитой эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтан, Улсын Их Хуралд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: 1. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж батлуулсан эсэх; 2. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэл зорилго, үр дүндээ хүрсэн эсэх; 3. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой үнэлж, тайлагнан, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан 6 бүлэг, 23 зорилт, 300 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт үр дүнг хариуцан тайлагнах, үнэлж дүгнэх 22 үндсэн байгууллага, богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд нэгтгэн тайлагнаж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дүгнэсэн Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар, бусад холбогдох байгууллага, агентлаг, тэдгээрийн ажлын албад хамрагдсан болно.

Ерөнхий мэдээлэл

УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-г 6 бүлэг, 23 зорилго бүхий 300 ТАХ-г хэрэгжүүлэхээс 262 ТАХ-д нийт 11,714.0 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай гэж баталсан байна.

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний 300 ТАХ-ний хэрэгжилт, үр дүнгээр 82 ТАХ буюу 27.3 хувь нь үр дүнтэй хэрэгжиж, 71 ТАХ буюу 23.7 хувь нь тодорхой үр дүнд хүрч, 88 ТАХ буюу 29.3 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 59 ТАХ буюу 19.7 хувь нь үр дүнгүй буюу зорилтот үр дүнг хангаагүй бөгөөд нийт 3,787.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний нийт гүйцэтгэл, үр дүнгийн **дундаж үнэлгээ 60.1 хувьтай** байгаагаас "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 95 хувь, Хүний хөгжлийн бодлого 65.0 хувь, Эдийн засгийн бодлого 51.2 хувь, Засаглалын бодлого 60.5 хувь, Ногоон хөгжлийн бодлого 49.5 хувь, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого 83.5 хувийн дундаж үнэлгээтэй байна.

¹ 4.1.1."хөгжлийн бодлого" гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг;

² УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан " Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050"

³ УИХ-ын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоол "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл батлах тухай

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журамгүй, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг шинэчлэн батлаагүй байна

Улсын хэмжээнд “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журам”-ыг батлаагүйгээс Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, салбар, бүс, орон нутагт мөрдөж буй бодлогын баримт бичгийн бүртгэл, мэдээллийг нэгтгэх, бодлогын уялдааг ханган төлөвлөлт хийх, хэрэгжилт, үр дүнг нэгтгэх, түүнд хяналт тавих нөхцөл бүрдээгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөгөөнд тусгасан төслийн төлөвлөлт, төсөл хэрэгжих салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, холбогдох хүчин зүйлийн нөлөө, гарч болох эрсдэлийн тооцоо судалгааг салбарын мэдээлэл дээр нэгтгэж бодлого боловсруулах, дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргах зэрэг асуудлыг системтэйгээр тодорхойлох боломжгүй болгож байна.

Төрийн захиргааны зарим байгууллага салбарын онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нарийвчилсан аргачлал, журамгүй байна

Сангийн яам, ХХААХҮЯ, УУХҮЯ, БХБЯ, БШУЯ, ХНХЯ зэрэг төрийн захиргааны төв байгууллагууд салбарын онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, журамгүй, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг мөрдөж байгаа боловч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан чиглэлийг мөрдөж ажиллаагүй байна.

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний зорилго, зорилтыг дунд хугацааны хөгжлийн бодлогын хүрэх үр дүнтэй 252 төсөл, арга хэмжээг нийцүүлэн боловсруулсан байна

Засгийн газар нь ХБТТУТХ-ийн 9.3.2⁴-т “..., Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж...” бүрэн эрх, Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар⁵ нь уг хуулийн 9.4.2-т “Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу ...4.1.13⁶-д заасан баримт бичгийн төслийг ...боловсруулж, Засгийн газарт танилцуулах” чиг үүргийн дагуу “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төслийг 3 удаа өөрчлөн боловсруулсан байна.

Хүснэгт 1. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулсан хугацаа

№	Бодлогын нэр	Төсөл боловсруулсан хугацаа	Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд тусгасан			
			Бүлгийн тоо	Зорилтын тоо	ТАХ-ий тоо	Санхүүжих дүн /тэрбум төгрөг/
1	Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө	2021 оны 4 сарын 15	5	10	326	13,182.7
2		2021 оны 5 сарын 14	5	11	263	10,782.7
3		2021 оны 6 сарын 30	6	23	301	11,714.0

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газраас ЗГХЭГ-т 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдөр, ЗГХЭГ-аас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газрын хуралдаанд хэлэлцсэн “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төсөл.

Сангийн сайд “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төсөлд тусгасан шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хянаж санал өгсөн боловч төсөл, арга хэмжээ нэг бүрд шаардагдах хөрөнгө бодитой эсэхийг хянасан тооцоолол, нотлох баримтгүй байгаа нь ХБТТУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.5.3-т “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, ...” гэж заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Засгийн газраас УИХ-д 5 дугаар сарын 25-ны өдөр анх өргөн мэдүүлсэн 263 төслөөс нийт 3.4 их наяд төгрөгийн 47 ТАХ-г хасаж, УИХ-д дахин 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн төсөлд шинээр 4.0 их наяд төгрөгийн 85 ТАХ нэмж тусгасан нь холбогдох байгууллагын саналд үндэслээгүй, УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний “Хүний хөгжил” 20, “Эдийн засаг” 41, “Засаглал” 9,

⁴ 9.3.2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

⁵ Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн ээлжит бус хуралдаан ЭЗХЯ-ны стратегийн чиг үүрэг, бүтэц, орон тоог баталсан.

⁶ 4.1.13. “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;

“Ногоон хөгжил” 3, “Нийслэл ба бүс орон нутаг” 12, нийт 3,973.9 тэрбум төгрөгийн 85 ТАХ байна.

Хүснэгт 2. Засгийн газраас УИХ-д 2021.06.30-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл”-д нэмэгдсэн ТАХ-ний нэгтгэл /тэрбум.төгрөг/

№	Бодлогын нэр	Төсөл, арга хэмжээний	
		Шинээр нэмэгдсэн тоо	Шаардагдах санхүүжилт
1	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	-	-
2	Хүний хөгжлийн бодлого	20	554.8
3	Эдийн засгийн бодлого	41	1,936.1
4	Засаглалын бодлого	9	79.2
5	Ногоон хөгжлийн бодлого	3	9.3
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	12	1,394.4
Дүн		85	3,973.9

Эх сурвалж: ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төсөл

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн хүрэх үр дүнтэй төлөвлөгөөний 48 төсөл, арга хэмжээг уялдуулан боловсруулаагүй байна

УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 300 ТАХ-ээс УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл”-ийн бодлогын хүрэх үр дүнтэй нийт 9,257.6 тэрбум төгрөгийн шаардагдах хөрөнгөтэй 252 ТАХ-г уялдуулан боловсруулсан ч, 2,456.4 тэрбум төгрөг шаардагдах хөрөнгөтэй 48 ТАХ-г бүрэн нийцүүлэн төлөвлөж батлаагүй байна.

Хүснэгт 3. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний бодлого, ТАХ нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл”-ийн бодлогын хүрэх үр дүнтэй уялдсан нэгтгэл

№	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл”-ийн				Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний бодлого, ТАХ-ний уялдаа	
	Бодлогын нэр	Зорилгын тоо	Зорилтын тоо	Хүрэх үр дүнгийн тоо	тоо	Шаардагдах хөрөнгө /тэрбум.төг/
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	1	5	16	2	0.3
2	Хүний хөгжил	1	7	49	75	824.9
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	1	6	27	19	873.9
4	Эдийн засаг	1	6	35	35	3,787.7
5	Засаглал	1	6	25	17	15.7
6	Ногоон хөгжил	1	4	18	25	406.4
7	Амар тайван, аюулгүй нийгэм	1	5	24	17	104.5
8	Бүс, орон нутгийн хөгжил	1	3	29	54	3,027.6
9	Улаанбаатар ба дагуул хот	1	5	20	8	216.5
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл”-ийн хүрэх үр дүнтэй		уялдсан ТАХ			252	9,257.6
		уялдаагүй ТАХ			48	2,456.4
Дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогод тусгасан ТАХ-ний нийт дүн		9	47	243	300	11,714.0

Эх сурвалж: УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол, УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоол

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 53 ТАХ-г Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулан боловсруулаагүй байна

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-д тусгасан 2,045.9 тэрбум төгрөгийн 53 ТАХ-г “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-тэй уялдуулаагүй нь ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.10.2-т “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон..., тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай ТАХ-г эрэмбэлсэн байх;” гэж заасан шаардлагыг бүрэн мөрдлөг болгоогүй, дунд, богино хугацааны төлөвлөлтийг дээрээс доош төлөвлөх, нэгдмэл цогц⁸ байх зарчим хангагдаагүй байна.

⁷ 4.1.13. “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;

⁸ 5.2.12. “төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим” гэж “дээрээс доош” төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, “доороос дээш” төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг;

Хүснэгт 4. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл, арга хэмжээ нь “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-тэй уялдсан судалгааны нэгтгэл

№	Бодлогын нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан эсэх		
			Шаардлагагүй	Тусгасан	Тусгаагүй
1	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	8	5	2	1
2	Хүний хөгжлийн бодлого	80	42	32	6
3	Эдийн засгийн бодлого	115	54	32	30
4	Засаглалын бодлого	53	41	6	5
5	Ногоон хөгжлийн бодлого	20	13	3	4
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	24	6	11	7
Дүн		300	161	86	53

Эх сурвалж: УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол, УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоол.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг уялдуулан боловсруулсан байна

ХБТТУТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3⁹, 6 дугаар зүйлийн 6.10.1¹⁰, 10 дугаар зүйлийн 10.1.3¹¹ дахь заалтын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 285 ТАХ-г Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2022 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулсан, 15 ТАХ нь уялдаагүй байна.

Хүснэгт 5. “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2022 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй “Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-тэй уялдуулсан судалгааны нэгтгэл

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө				Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний бодлого, ТАХ-тэй уялдаагүй						
Бодлогын нэр	Зорилтын тоо	Зорилтын тоо	Хүрэх үр дүнгийн тоо	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүний хөгжлийн бодлого	Эдийн засгийн бодлого	Засаглалын бодлого	Ногоон хөгжлийн бодлого	Нийслэл ба бүс, орон нутгийн		
Засгийн газрын 2020-2024 оны ҮАХХАХТ-ний 2022 оны хүрэх үр дүнтэй	259	1040	957	8	80	115	53	20	24	
уялдсан ТАХ-ний тоо	285			3	79	104	69	20	9	
уялдаагүй ТАХ	15			-	6	8	-	1	0	

Эх сурвалж: УАГ-ийн тооцоолол

Үндэсний статистикийн хороо нь ХБТТУТ хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна

Үндэсний статистикийн хорооноос улсын хэмжээний жил бүрийн эдийн засаг, нийгэм, салбаруудын тоон мэдээллийг үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлэх, ХБТТУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.7.1¹², 9.7.2¹³-т заасан хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй¹⁴, тус байгууллагаас Статистикийн тухай хуулийг үндэслэн гаргадаг улсын хэмжээний нэгдсэн тоо, мэдээлэл нь дараа оны 2-5 дугаар сард гарч байгаа нь бодлого боловсруулахад цаг хугацааны хувьд бодит мэдээлэлд үндэслэх боломжгүй болгож байна.

⁹ 5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

¹⁰ 6.10.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх;

¹¹ 10.1.3.бодлогын хувилбаруудад хүний хөгжлийн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн урьдчилсан үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдах байдлын үнэлгээ, үр ашгийн урьдчилсан тооцоо хийх;

¹² 9.7.1-т “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг тухай бүрд нь боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”

¹³ 9.7.2-т “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр, тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах”.

¹⁴ УАГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 08/17 дугаартай албан бичгийн хариуг ирүүлээгүй

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулахдаа зарим төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт /суурь түвшин, зорилтот түвшин/-ийг бодитой тодорхойлоогүй байна

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 21 төсөл, арга хэмжээний суурь түвшин¹⁵, зорилтот түвшнийг тоон болон чанарын утгаар илэрхийлээгүй, хэмжигдэхүйц бус, хэт ерөнхий илэрхийлсэн нь арга хэмжээний хүрсэн түвшнийг бодитой үнэлэх боломжгүй, үйл ажиллагааны хэрэгжилтээр үнэлэх нөхцөлийг бий болгосон байна.

Мөн төлөвлөгөөний “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого”-ын 2 ТАХ-ний суурь түвшнийг ам.доллараар илэрхийлсэн нь *Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1¹⁶-т заасантай нийцээгүй байна.*

Зарим төсөл, арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон нотлох баримтгүй, 28 төсөл, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг тусгаагүй байна

“Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулахад 27 төрийн захиргааны байгууллагаас нийт 67,838.5 тэрбум төгрөгийн 895 ТАХ хүргүүлснээс 3,417.7 тэрбум төгрөгийн шаардагдах хөрөнгөтэй 219 ТАХ, Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан ТАХ-ээс 30.5 хувь буюу 66 ТАХ-ний 1,966.8 тэрбум төгрөгийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг урьдчилан тооцоолсон эсэхийг саналын тайлбар, тодруулгад бичээгүй, нотлохуйц бус байгаа нь ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.10.2-т “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон,...” гэсэн заалттай бүрэн уялдаагүй байна.

Мөн Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 28 ТАХ нь шаардагдах хөрөнгө, эх үүсвэргүй батлагдсан нь ХБТТУТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж ...тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан...бичгийг;”, 11 дүгээр зүйлийн 11.2-т “... хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд ..., эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, ... тусгана” гэж заасан хуулийн шаардлагыг хангаагүй байна.

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд Хүний хөгжлийн бодлогын 1, Эдийн засгийн бодлогын 3, Засаглалын бодлогын 1 ТАХ-нд шаардагдах хөрөнгийн дүнг тусгаагүй ч эх үүсвэрийг заасан, газрын асуудал бүрэн шийдэгдээгүй зэрэг 5 арга хэмжээг тусгаснаас төлөвлөгөөний биелэлт хангагдахгүй байх нөхцөл байдлыг бий болгосон байна.

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй 20 төсөл, арга хэмжээг баталсан байна

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд ТЭЗҮ, зураг төсөв шаардлагагүй 125, ТЭЗҮ, зураг төсөвтэй 113, ТЭЗҮ, зураг төсөвгүй 20 ТАХ-г хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан нь ХБТТУТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2¹⁷, 9 дүгээр зүйлийн 9.12.2¹⁸, Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30¹⁹ дахь заалтын дагуу Улсын хөгжлийн төлөвлөгөөнд ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан ТАХ-г тусгаж батлуулахаар зохицуулсантай нийцээгүй байна.

¹⁵ 4.1.20 дахь хэсэгт “суурь түвшин” гэж төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын утгыг;

¹⁶ 4.1.Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.

¹⁷ 6.10.2.санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх;

¹⁸ 9.12.2.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон нэмж тусгах төсөл, хөтөлбөрийн бодлогын судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

¹⁹ 4.1.30.“зураг төсөл” гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

БҮЛЭГ 2. УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 49.0 ХУВЬ НЬ ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ, ҮР ДҮНГҮЙ БАЙНА

УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-д тусгасан нийт 300 ТАХ-ээс 82 буюу 27.3 хувь нь үр дүнтэй хэрэгжиж, 71 буюу 23.7 хувь нь тодорхой үр дүнд хүрч, 88 буюу 29.3 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 59 буюу 19.7 хувь нь үр дүнгүй буюу зорилтот үр дүнг хангаагүй байна. /дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/

Хүснэгт 8. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний ТАХ-ний үр дүнгийн үнэлгээний нэгтгэл

№	Бодлогын нэр	ТАХ-ний тоо	Үр дүнгийн үнэлгээ			
			үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн	эрчимжүүлэх шаардлагатай	үр дүнгүй
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	8	6	2	-	-
2	Хүний хөгжлийн бодлого	80	24	23	21	12
3	Эдийн засгийн бодлого	115	20	21	46	28
4	Засаглалын бодлого	53	17	13	12	11
5	Ногоон хөгжлийн бодлого	20	1	7	6	6
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	24	14	5	3	2
Нийт дүн		300	82	71	88	59
нийт дүнд эзлэх хувь			27.3	23.7	29.3	19.7

Эх сурвалж:ҮАГ-ын тооцоолол

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэл зорилтоо бүрэн хангаагүй байна

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 300 төсөл, арга хэмжээнээс 147 буюу 49.0 хувь нь “эрчимжүүлэх шаардлагатай”, “үр дүнгүй” үнэлгээтэй байгаа нь зарим төсөл, арга хэмжээний шаардагдах улсын төсвийн хөрөнгийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлаагүй, “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хүрээнд зарим төсөл, арга хэмжээнд санхүүжилт шийдэгдээгүй, дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр БНХАУ-ын хил тодорхойгүй хугацаагаар хааснаас тээвэр логистик зогссон, мөн хамтран хариуцагч байгууллагын ажлын уялдаа хангалтгүй, зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлээгүй зэрэг шалтгаанаас байна

Мөн УИХ-ын 2021 оны “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” 56 дугаар тогтоолын 2-т “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнөөс улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай ТАХ-г ...уялдуулан Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах...” гэж заасан ч “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль”-ийн “Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ, барилга байгууламжийн жагсаалт”-д 24 ТАХ, түүнд шаардагдах 3,188.4 сая төгрөгийн хөрөнгийг батлаагүй, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүйгээс хэрэгжих боломжгүй болж зорилтот үр дүнд хүрээгүй байна.

Энэ нь ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.10.3²⁰-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэсэн шаардлага, 9 дүгээр зүйлийн 9.5.3-т “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах” гэсэн заалтыг Сангийн сайд бүрэн хэрэгжүүлээгүйгээс тухайн ТАХ хэрэгжээгүй, зорилтот үр дүнд хүрээгүй, богино хугацааны зорилго биелэхгүй болж, улмаар дунд хугацааны бодлогын үр дүнд сөрөг нөлөөллийг бий болгох нөхцөлийг үүсгэж болзошгүй байна

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан 8 ТАХ-нд хэрэгжилтийг өөр ТАХ-ний хэрэгжилтээр тайлагнасан байхад шат шатны хяналтын нэгж нь тайлагналд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж баталгаажуулсан нь бодитой бус байна

ХХМТГ /хуучин нэрээр/ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 14 арга хэмжээ тусгаснаас Засгийн газрын хяналт-шинжилгээ үнэлгээний цахим хуудсанд 13 ТАХ-ний хэрэгжилтийг тайлагнаж, салбарын яамны хариуцлагагүй байдлаас үүдэн тайланг үнэн зөв тайлагнаагүй, 4

²⁰ 6.10.3.улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

ТАХ-ний хэрэгжилтийг бодит бусаар /өөр ТАХ-ний хэрэгжилтийг оруулж/ тайлагнасан, хяналт-шинжилгээг хийхдээ нотолгоонд үндэслээгүй, ТЕЗ-ийн тайлагналд үндэслэж үнэлгээг хийсэн нь бодитой бус байна.


Дээрх зөрчлүүд нь ТАХ-ний хэрэгжилт, үр дүнгийн тайланд ТЕЗ, ЭЗХЯ, ЗГХЭГ-ын шат шатанд үнэлгээг хяналтгүйгээр гаргасан, холбогдох албан тушаалтны хариуцлага сул, ажлын уялдаа, зохион байгуулалт, хяналт хангалтгүйгээс бодит хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээг нотолгоонд суурилж хийгээгүй, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 3.1.4²¹ дэх заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийг 354.2 тэрбум төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт 300 ТАХ-ний хэрэгжилт, үр дүнд нийт 3,787.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн байхад Засгийн газар нь 4,141.3 тэрбум төгрөг гэж тайлагнасан нь бодит гүйцэтгэлээс 354.2 тэрбум төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн дүнгээр тайлагнасан буюу бодит гүйцэтгэлийг тайлагнаагүйтэй холбоотой байна. /дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу/

Хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ЭЗХЯ, ЗҮХЭГ, ҮАГ-ын “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэл, үр дүнгийн дундаж үнэлгээг дараах дүрслэлээр харьцуулан харуулбал:

Дүрслэл 1. ЭЗХЯ, ЗГХЭГ, ҮАГ-ын “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээний харьцуулалт



Эх сурвалж: Засгийн газрын танилцуулга, ҮАГ-ын үнэлгээний нэгтгэл

²¹ 3.1.4. хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх;

БҮЛЭГ 3. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БАРИМТ НОТОЛГООНД ҮНДЭСЛЭЖ БОДИТОЙ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА

ЭЗХЯ нь “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем”-ийг шинэчлэх ажлыг хийгээгүй, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлээгүйгээс ХБТТУТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2⁵⁰-т “Мэдээллийн нэгдсэн санд ... хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, түүнтэй холбогдох тайлан, судалгаа, шинжилгээ, тооцоолол, дүгнэлт, зөвлөмжийг дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлнэ”, 22.5-т “..., мэдээллийн сангийн ангилалт, бүрдүүлэлт, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, программчлал, хөгжлийн загвар боловсруулалт, шинэчлэлийг хариуцан зохион байгуулна” гэж заасан мэдээллийн нэгдсэн сангийн системийг хөгжүүлэх, үр нөлөөг бий болгох ажил орхигдсон байна.

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах журам”⁵¹-аар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх, улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулахтай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулсан ч хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн системгүй, мэдээллийн нэгдсэн тогтолцоогүй нь ХБТТУТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.422-т “Холбогдох байгууллага, албан тушаалтан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санд оруулах үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Үндсэн хариуцагч байгууллагууд улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтийг ЗГХЭГ ЭЗХЯ-д хүргүүлээгүй байна

ХБТТУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.6.1²³, 9.6.4²⁴ дэх заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу ХХААХҮЯ, ОБЕГ, ЖҮХ нь жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг хугацаа хоцроож хүргүүлсэн бол ЗГХЭГ, МХЕГ, БССАА, ТАЗ,СЗХ нь жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан ТАХ-г хэрэгжүүлсэн гүйцэтгэлийн тайланг ЭЗХЯ-д хүргүүлээгүй нь холбогдох журамтай нийцэхгүй байна.

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд богино хугацааны “Улсын хөгжлийн төлөвлөгөө”-ний “гүйцэтгэлийг тайлагнах” хэсэгт Сангийн яам нь 2022 оны хагас жил, 2022 оны IX сард 6 арга хэмжээг бүрэн тайлагнасан, 2022 оны X–XI сар, жилийн эцэст 5 арга хэмжээг тайлагнахдаа 3.1.3. “Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, сайжруулах” ТАХ-г хасаж, 2022 оны жилийн эцэст тайлагнагдаагүй²⁵ байна.

“Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүнд шат шатны хяналт хангалтгүй, нотолгоонд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүйгээс ТАХ-ний хэрэгжилт, үр дүн бодитой биш байна

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 300 төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хариуцан хэрэгжүүлэгч 26 үндсэн байгууллагаас 9 байгууллага нь 62 арга хэмжээний нотлох баримтыг хавсаргасан ч 17 байгууллага нь 238 төсөл, арга хэмжээний нотлох баримтыг хавсаргаагүй, тухайн ТЕЗ-ийн, ЭЗХЯ-ны, ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан

²² Холбогдох байгууллага, албан тушаалтан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санд оруулах үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

²³ 9.6.1.энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-д заасан баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцох;

²⁴ 9.6.4.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хууль тогтоомжид заасан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүгнэлтийг Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

²⁵ Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хасагдсан, Боомтын сэргэлтийн Сайдын ажлын албанд шилжсэн, тухайн ТАХ-г хасуулах саналыг 2022.11.02-ны өдөр ЗГХЭГ-т албан и-мэйл-ээр хүргүүлсэн гэх шалтгаантай.

нэгжээс ТAХ-ний хэрэгжилтийг нотолгоонд үндэслэж хяналт-шинжилгээг хийгээгүй, үнэлгээг бодитой гаргаагүй байна.

Дүрслэл 2. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн нотлох баримтыг системд оруулсан эсэх судалгаа



Эх сурвалж: Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний дотоод систем /www.unelgee.gov.mn/

Монгол Улсын Засгийн газрын хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн системд хэрэгжилтийн тайланд нотлох баримт хавсаргаж оруулаагүй, бодитой үнэлэлт, дүгнэлтийг өгөөгүй байгаа нь Засгийн газрын 2020 онд 206 дугаар тогтоолоор баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 5.2.3 дахь хэсэгт заасан “хяналт-шинжилгээ, үнэлгээний үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах,” гэж заасантай нийцээгүй, хяналт-шинжилгээ үнэлгээг журамд заасан чиг үүргийн дагуу гүйцэтгээгүй, хуулийн 5.2.4. “тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгах” гэсэн заалтыг үндэслэхгүйгээр үнэлгээг хийж байгаа нь бодит бус байна.

ДҮГНЭЛТ

Аудитаар цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журам болон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг боловсруулаагүй, зарим салбарын онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ үнэлгээний нарийвчилсан аргачлалгүй байна.
2. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 300 төсөл, арга хэмжээнээс Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөгжлийн зорилт, хүрэх үр дүнтэй 252 төсөл, арга хэмжээг уялдуулж тусгасан байна.
3. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоолол судалгаа хийгдээгүй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулаагүй зэрэг хуулийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг тусгасан нь бодлогын зорилго, зорилт, хүрэх үр дүн биелэх нөхцөлийг бууруулж байна.
4. Үндэсний статистикийн хороо улсын хэмжээний нэгдсэн тоо, мэдээллийг харилцан адилгүй хугацаанд салбарын онцлогоос нь хамааруулан тархааж байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүрэгтэй нийцэхгүй, хөгжлийн бодлогыг төлөвлөхөд үндэслэл бүхий мэдээлэл болохгүй байна.
5. Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулахдаа зарим төсөл, арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшнийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгийн хэмжээг урьдчилан тооцоолоогүй байна.
6. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэл, үр дүнгийн дундаж үнэлгээ **60.1 хувьтай** байгаагаас “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого **95 хувь**, Хүний хөгжлийн бодлого **65.0 хувь**, Эдийн засгийн бодлого **51.2 хувь**, Засаглалын бодлого **60.5 хувь**, Ногоон хөгжлийн бодлого **49.5 хувь**, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого **83.5 хувь** байна.
7. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн тайлагнал, хэрэгжилтэд хийсэн хяналт хангалтгүй, шат шатны хяналт-шинжилгээ, үнэлгээг нотолгоонд үндэслэж хийгээгүй байна.
8. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд туссан зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй нь Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд санхүүжих эх үүсвэрийг тусгаагүй, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай нийцэлгүй байна.
9. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн **хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт таван жилийн хүрэх түвшнээр батлагдсан нь** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т²⁶ заасны дагуу **төсөл, арга хэмжээ тус бүрийг хувиар харьцуулан үнэлж, дүгнэх боломжгүй** байна.

²⁶ 17.1.2. “тухайн жилийн биелэлт нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлт хангасан эсэхийг төсөл, арга хэмжээ тус бүрийн хувиар харьцуулан;”

УИХ-д толилуулах асуудал

“Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй төсөл арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасантай нийцүүлэхийг тухайн жилийн төсвийн тухай хууль хэлэлцэхдээ анхаарал хандуулахыг толилуулж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Монгол Улсын Шадар сайд бөгөөд, Эдийн засаг, хөгжлийн сайдад:

1. Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг тус тус боловсруулан батлах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллийг эргэлтэд оруулах хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх;
2. Улсын хөгжлийн богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа дунд хугацааны бодлогын зорилго, зорилтын хүрэх үр дүнтэй нэгдмэл цогц, харилцан уялдаатай байх зарчмыг баримталж, хуулийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгаж боловсруулах;
3. Жил бүрийн Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн урьдчилсан тооцоолол судалгааг бодитой хийж, арга хэмжээний суурь болон зорилтот түвшний үзүүлэлтийг тоон ба чанарын утгаар бүрэн илэрхийлж, хэмжигдэхүйцээр тодорхойлж, боловсруулах;
4. Улсын хөгжлийн богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зарцуулсан хөрөнгийн дүнг үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт тавьж, хүрсэн үр дүнг нотлох баримтад үндэслэн цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх;
5. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийхэд оролцож буй төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтанд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх үе шат бүрд нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:

1. Улсын хөгжлийн богино хугацааны бодлогын баримт бичгийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ Монгол Улсад нэн шаардлагатай, хөгжил, дэвшил авчрах, дунд хугацааны бодлогын зорилго, зорилтын хүрэх үр дүнтэй нэгдмэл цогц, харилцан уялдаатай байх зарчмыг бүрэн хангах төсөл, арга хэмжээг тусгасан эсэхийг хянаж байх;
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасантай нийцүүлэн “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээг тусгасныг эсэхийг хянаж, жил бүрийн төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;
3. Төрийн мэдээллийн сүлжээ www.unelgee.gov.mn цахим системийг боловсронгуй болгож, хөгжлийн богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, зарцуулсан хөрөнгийн дүнг үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт тавьж, хүрсэн үр дүнг нотлох баримтад үндэслэн цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой хийж байх.

Сангийн сайдад:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.3.-т *“Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах”* гэж заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Үндэсний статистикийн хорооны даргад:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.1-т *“хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг тухай бүрд нь боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”* гэж заасны дагуу тухай бүрд нь улсын хэмжээний тоон мэдээллийг хүргүүлэх;
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.2-т *“үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр, тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах”* гэж заасан хуулиар хүлээсэн чиг үүргээ тус тус хэрэгжүүлэх.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Жил бүрийн Улсын хөгжлийн төлөвлөгөөний төсөлд хүргүүлж буй төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн урьдчилсан тооцоолол, судалгааг үндэслэлтэй гаргаж, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь, зорилтот түвшнийг тоон болон чанарын утгаар бүрэн илэрхийлж, хэмжигдэхүйцээр тодорхойлж төлөвлөж байх;
2. Улсын хөгжлийн богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилтийн хүрсэн үр дүнг тайлагнаж, нотлох баримтад тулгуурласан хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой хийж хэвших.

Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан нийт төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээний нэгтгэл

/тэрбум.төгрөг/

№	Бодлогын нэр	Нийт дүн			Үр дүнгийн үнэлгээний нэгтгэл											
					үр дүнтэй			тодорхой үр дүнд хүрсэн			эрчимжүүлэх шаардлагатай			үр дүнгүй		
		TAX-ний тоо	шаардаг дах хөрөнгө	зарцуул сан хөрөнгө	TAX-ний тоо	шаардаг дах хөрөнгө	зарцуул сан хөрөнгө	TAX-ний тоо	шаардаг дах хөрөнгө	зарцуул сан хөрөнгө	TAX-ний тоо	шаардаг дах хөрөнгө	зарцуул сан хөрөнгө	TAX-ний тоо	шаардаг дах хөрөнгө	зарцуул сан хөрөнгө
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	8	300.3	385.1	6	299.1	385.1	2	1.2	-	-	-	-	-	-	-
2	Хүний хөгжлийн бодлого	80	851.2	1,065.7	24	29.5	40.5	23	492.0	381	21	176	622.2	12	154	21.8
3	Эдийн засгийн бодлого	115	8,145.1	1,329.8	20	545.9	394.9	21	1,938.5	345	46	3,363	549.8	28	2,298	40.6
4	Засаглалын бодлого	53	268.5	28.3	17	82.7	14.4	13	40.4	12.6	12	125.4	0.0	11	20	1.3
5	Ногоон хөгжлийн бодлого	20	304.9	79.1	1	10.7	4.8	7	52.1	41	6	24	7.0	6	218	26.3
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	24	1,843.9	899.0	14	266.6	260.1	5	234.1	102	3	259	116.7	2	1,085	420.0
Нийт дүн		300	11,714.0	3,787.1	82	1,234.5	1,099.8	71	2,728.3	881.5	88	3,947	1,295.8	59	3,774	510.0
нийт дүнд эзлэх хувь					27.3	10.5	29.3	23.7	23.3	23.2	29.3	33.7	34.1	19.7	32.2	13.4

Эх сурвалж: УАГ-ын үнэлгээний нэгтгэл

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн тайлагналын нэгтгэл

/тэрбум төгрөг/

Эх үүсвэр	Бүлэг 1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого		Бүлэг 2. Хүний хөгжлийн бодлого		Бүлэг 3. Эдийн засгийн бодлого		Бүлэг 4. Засаглалын бодлого		Бүлэг 5. Ногоон хөгжлийн бодлого		Бүлэг 6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого		Нийт		
	Засгийн газрын тайлагнасан	Аудитаар хянасан	Засгийн газрын тайлагнасан	Аудитаар хянасан	Засгийн газрын тайлагнасан	Аудитаар хянасан	Засгийн газрын тайлагнасан	Аудитаар хянасан	Засгийн газрын тайлагнасан	Аудитаар хянасан	Засгийн газрын тайлагнасан	Аудитаар хянасан	Засгийн газрын тайлагнасан	Аудитаар хянасан	Зөрүү
Улсын төсөв	-	-	727.5	947.6	113.7	100.8	10.4	27.0	40.4	6.3	280.2	530.1	1,172.3	1,611.8	(439.6)
Гадаадын зээл, тусламж	346.1	385.1	25.3	38.5	1,014.1	469.9	-	0.0	4.3	-	406.7	319.9	1,796.5	1,213.4	583.1
Орон нутгийн төсөв	-	-	-	-	0.2	-	-	-	-	24.9	29.0	49.0	29.2	73.9	(44.7)
Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэл	-	-	-	-	-	69.1	-	-	40.0	-	-	-	40.0	69.1	(29.1)
Төр-хувийн хэвшлийн түншлэл	-	-	10.5	29.9	1,023.7	400.8	-	-	-	38.7	-	-	1,034.2	469.4	564.8
Бусад эх үүсвэр	-	-	-	-	-	263.4	-	-	-	9.1	-	-	-	272.5	(272.5)
Тусгай сан	-	-	49.9	49.7	19.2	25.9	-	1.3	-	0.1	-	-	69.1	77.0	(7.9)
Нийт зарцуулсан хөрөнгийн дүн	346.1	385.1	813.3	1,065.7	2,170.8	1,329.8	10.4	28.3	84.7	79.1	715.9	899.0	4,141.3	3,787.1	354.2

Эх сурвалж: УАГ-ын тооцоолол

